

Ажилгүйдлийн тэтгэмж авах эрх:



Даатгуулагч дараах нөхцөлийг хангасан тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж авах эрх анх үүснэ:

- Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг нийтдээ 24 сар ба түүнээс дээш хугацаанд, үүнээс ажилгүй болохын өмнөх сүүлийн 9 сар тасралтгүй төлсөн, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрээгүй даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй.

Ажилгүйдлийн тэтгэмжийг дахин авах эрх:

Урьд нь ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг дахин 12 сар, үүнээс ажилгүй болохын өмнөх 3 сар тасралтгүй төлсөн нөхцөлд тэтгэмж авах эрх нь дахин үүснэ.

Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ:

Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг түүний шимтгэл төлсөн хугацааг харгалзан ажилгүй болохын өмнөх шимтгэл төлсөн сүүлийн дараалсан 9 сарын дундаж цалин хөлс, орлогоос дараах хувь, хэмжээгээр тооцож олгоно:

Ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа (сараар)	Тэтгэмж бодох хэмжээ (хувиар)
24-59	50
60-119	55
120-179	60
180 ба түүнээс дээш	70

Ажилгүйдлийн тэтгэмж олгох:

- Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг ажлаас чөлөөлсөн өдрийн дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр тооцож олгоно.
- Хүүхдээ асрах чөлөө авахаас өмнө ажилгүйдлийн тэтгэмж авах эрхийг хангасан даатгуулагч эхийг хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд, эсхүл ажилдаа ороод 9 сар хүртэлх хугацаанд ажил олгогч нь татан буугдсан, дамбуурсан бол түүнд ажилгүйдлийн тэтгэмж олгоно.
- Ажилгүйдлийн тэтгэмж бодох хугацаанд нийтээр тэмдэглэх баярын өдөр тохиосон бол уг өдрийг ажлын өдөртэй адилтган тооцож олгох тэтгэмжийг бодно.

Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт илгээх:

Даатгуулагч Та ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ <https://daatguulagch.ndaatgal.mn/>

цахим хаягаар нийгмийн даатгалын байгууллагад илгээж болно.

Ажилгүйдлийн тэтгэмж авахад бүрдүүлэх бичиг баримт (цаасан, эсхүл цахим хэлбэрээр):

- Тэтгэмж авахыг хүссэн өргөдөл;
- Ажлаас чөлөөлсөн тухай ажил олгогчийн шийдвэр (шийдвэрт хамаарах хугацаа нь дуусгавар болж буй ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ болон эдгээртэй адилтгах бусад гэрээний хамт);
- Хөдөлмөрийн эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад бүртгүүлсэн тухай тодорхойлолт.